

Хүлгийн дүрслэлийг судар дахь шинж, хэмжээст их хайрцаглах аргачлалаар судлах нь

Энхтайваны Гансүх 

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын
ахлах сургууль, Улаанбаатар, Монгол Улс
✉ gansukh@must.edu.mn

Хураангуй: Энэхүү судалгаанд уламжлалт хүлгийн соёлыг уран бүтээлээр хэрхэн тусган дүрсэлж буйг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан болно. Судалгааны зорилго нь хүлгийн шинжийн судруудад тэмдэглэсэн хүлгийн гадаад шинжийн дүрслэлийг орчин үеийн уран бүтээлчдийн бүтээл дэх дүрслэлтэй харьцуулан судлах болно. Үүний тулд судалгааны эх сурвалжууд болох “Мэргэн толь судар”, “Эрдэнэт хүлгийг шинжих ба уях засах судар оршив”, “Ханд вангийн хүрээний хурдан морины шинжийн нууц судруудын жинхэнэ эх оршвой”, “Шигамуни бурханд мөргөмүй, Манзуширт залбирмуй”, “Морины шинжийн нэгэн судар” дахь хүлгийн шинжийг дүрслэн бичсэн тодорхойлолтыг үндэслэн дөрвөн уран бүтээлчийн нэг, нэг бүтээлийг сонгон “Өртөөлөн дүрслэх арга зүй”-н “Хэмжээст их хайрцаглах аргачлал”-аар бүтээлүүдэд тоон аргаар дүн шинжилгээг хийж, гарсан үр дүнг танилцуулав.

Судалгааны үр дүнд дээрх сударт дурдсан хүлгийн гадаад төрх, шинж чанарын дүрслэл нь сонгогдсон бүтээлүүдийн дүрслэлтэй олон талаараа нийцэж байгааг тогтоов. Монголын орчин үеийн уран бүтээлчид ч хүлгийн шинжийг судалж, уран бүтээлдээ тусган харуулдаг болохыг харуулж байна. Иймд энэхүү судалгаа нь адууны соёлын өв, уран бүтээлчдийн арга зүй, уламжлалын уялдаа холбоог судлах үндэстэй эх сурвалж болох ач холбогдолтой гэж үзэж байна.

Түлхүүр үгс: *хэмжээст их хайрцаглах аргачлал, хүлгийн шинж, хүлгийн дүрслэл, хүлгийн шинжийн судар*

Studying racehorse depictions via scriptural character and dimensional box analysis

Gansukh Enkhtaivan 

High School, Mongolian University of Science and Technology,
Ulaanbaatar, Mongolia
✉ gansukh@must.edu.mn

Abstract: This study presents a scientifically grounded examination of how traditional Mongolian culture surrounding swift horses is visually represented in

contemporary artworks. The research aims to compare the external characteristics of fast horses, as described in classical equine scriptures, with their portrayal in modern artistic creations. The analysis draws upon primary textual sources, including The Mergen toil Scripture, The Scripture on Erdenitü külüg-ün singjikü ba uyaqu jasaqu sudur orusibai, The scriptures on tqangdu vang-un küriyen-ü qurdun morin-u singji-yin niguča sudur-uud-un jingkini eke orusibai, The scriptures on sigamuni burqan-du mörgümüi, mangjusiri-du jalbarimui, The scripture on the Character of Racehorses. Based on these descriptions, one artwork from each of four contemporary artists was selected for analysis using the “Dimensional Box Analysis Method” within the framework of the “Sequential Descriptive Methodology.” A quantitative approach was employed to evaluate the extent to which the traditional equine features are reflected in the selected artworks.

The findings reveal a significant alignment between the traditional textual descriptions and the visual representations of swift horses in the selected works, suggesting that contemporary Mongolian artists possess a nuanced understanding of equine traits and consciously integrate this knowledge into their creative practice. This research provides valuable insight into the intersection of cultural heritage, artistic methodology, and traditional knowledge, offering a foundation for further interdisciplinary studies on Mongolian equine culture.

Keywords: *dimensional box analysis method, character of racehorses, depiction of racehorses, racehorses scriptures*

Оршил

Монголын дүрслэх урлагт хүлэг¹ морины дүрслэл олон буй. Монгол уран бүтээлчид хүлэг морины дүрслэлийг бүтээл туурвилдаа ихээхэн ашиглан бүтээдэг билээ. Энэ удаа монгол хүлгийн дүрслэлээр уран бүтээл хийдэг бүтээлчдээс төлөөлүүлэн дөрвөн бүтээлчийн хүлгийн дүрслэлд нь дүн шинжилгээг “Хэмжээст их хайрцаглах аргачлал”-аар хийсэн үр дүнг танилцуулах болно.

Иймийн учир монгол уяачид хүлгийг галбираар нь “Хайрцаг тэнцүүлэх”³ хэмээн хэмждэг арга байдаг. Үүнд: “Их биеийн хайрцаг”⁴, “Гавлын хайрцаг”⁵,

¹ Хурдан морийг хүлэг гэдэг (Намнандорж 1989, 4), Алдар цуу бүхий гэсэн утгатай, агт, морь, баатар гэсэн үгийн тодотголоор тогтвортой хэрэглэгдэж байгаад улмаар нэршиж орчин цагийн монгол хэлэнд сайн морь, ажнайг нэрлэх болсон (Чоймаа 2017, 139).

² “Метаморфоз”-ын их квадратын А, В, D, C өнцөгт тааруулна. Их квадратад морины их бие багтана. Квадратын А өнцөгт бага квадратын төв босоо, хэвтээ тэнхлэгийг татан бага квадратыг байгуулна. Энэхүү байгуулсан бага квадратын өнцгийг a, b, c, d гэж тэмдэглэнэ. Бага квадратад морины хүзүү, толгой багтана.

³ Хайрцаг гэдэг нь үе хоорондын зайны нийлбэрийг хэлэх

⁴ Их биеийн хайрцаг бол өвчүүний бүдэрхийний хамгийн өндөр цэг дээрээс шонтон мөрний хамгийн өндөр цэг дээгүүр дамнуулаад, ташаан толгойны хамгийн өндөр цэг дээр нэг хэмжээ авна. Тэр хэмжээгээ сэрвээний хамгийн өндөр цэг дээрээс урд хөлийг дагуулаад доош нь буулгахад бэрэвхийний дээд үен дээр таарч байх ёстой. Энэ хэмжээ тэнцүү байвал хайрцаг тэнцсэн хүлэг гэж хэлнэ.

⁵ Магнай өргөн, түүшээ өргөн байх нь гавлын хайрцаг тэнцэл гэнэ.

“Цээжний хайрцаг”⁶, “Бөгсний хайрцаг”⁷ гэх мэт хэмжээсээр хэмждэг. Энэхүү “Хэмжээст их хайрцаглах аргачлал”-ын квадратыг хүлгийн цээжний урд тал, бөгсний хэсгийг хойд талд тулган багтаасан. Ингэж багтааснаар хүлгийн төрхийн дээд хэмжээст цэгийг тодорхойлох боломжтой. Эндээсээ дагз, харгам овооны цэг болон, хоорондын зайг тодорхойлно. Хүлгийн ерөнхий суурь дүрс дээр 14 характерын цэгийг тодорхойлон, тэрхүү цэгүүд дээрээ тулгуурлан дөрвөн бүтээлчийнхээ хүлгийн галбируудыг байрлуулсан. Дөрвөн хүлгийн суурь дүрслэл дээр 14 цэгийг тэмдэглэсэн. Үүнд: Хамрын үзүүр, хоншоорын цэг, аман хүзүүний цэг, хүзүүний гүдгэрийн цэг, омруу⁸-ны цэг, онжрого⁹-ны цэг, сэрвээ-мундаа овооны цэг, суга аюулхайн мөгөөрсний цэг, мундааны хойд цэг, нурууны хотгорын цэг, зоо нурууны цэг, харгам овооны цэг, сүүлний угийн цэг, хонго (өгзөг)-ны гадна талын цэг зэргүүдийг тэмдэглэж хүлгүүдийн ялгааг нь тодорхойллоо.

Судалгааны арга зүй

“Хэмжээст их хайрцаглах аргачлал” нь огторгуйн координат дээр голландын анатомич Петрус Кампер (1722-1789)-ын “Метаморфоз” онолд дөрвөлжнийг 9 тэнцүү хуваан амьтны хэлбэрийн өөрчлөлтийг тэмдэглэдэг аргачлалаас санаа авч боловсруулсан. “Метаморфоз”-ын квадратын А өнцгийг “Х”, “Z”-ийн 0 цэгт байрлуулан Фибоначчийн цуврал тооны 89 дээр квадратын В, D өнцөгт тааруулна. Квадратын А өнцөгт бага квадратын төв босоо, хэвтээ тэнхлэгийг татан бага квадратыг байгуулна. Энэхүү байгуулсан бага квадратын өнцгийг a, b, c, d гэж тэмдэглэнэ. Бага квадратад морины хүзүү, толгой багтана. Фибоначчийн цуврал тооны утга алтан харьцаагаар математикийн тогтмолыг ашиглах нь үнэнийг тодорхойлох боломж бүрдсэн юм (Гансүх 2025, 155). “Хэмжээст их хайрцаглах аргачлал” нь амьтны дундаж дүр төрхийн тодорхойлон, бүтээдэг “Өртөөлөн дүрслэх арга зүй”-н нэг хэсэг юм (Гансүх 2024, 247-258).

Энэхүү дөрвөн уран бүтээл дээр хийсэн хүлгийн ерөнхий суурь дүрс дээр 14 характерын цэгийг тодорхойлон, тэрхүү цэгүүдийн ялгаатай байдлыг харуулахыг зорьсон. Хүлгүүдийн өндөр, уртад хамаарах давтамжтай болон давтамжгүй характерын цэгүүд дээр хийсэн дүн шинжилгээний үр дүнд монгол уран бүтээлчид их насны морины дүрслэлийг, хэрхэн хүлгийн шинжид хамааруулан бүтээсэн талаар судаллаа.

Судалгааны үр дүн

Манай уран бүтээлчид дотор адуу малаа сайн мэддэг, удам дамжсан хүлэг шинжээчид бий. Хүлэг морьдын галбарт дүн шинжилгээ хийхэд уран бүтээлчид өөрийн бодол санаа, итгэл үнэмшлээрээ бүтээдэг. Энэ нь ч зөв. Уран бүтээлч хүн ямарваа уран бүтээл туурвихдаа өөр, өөрийн мэдрэмж, авьяас чадвараас хамаарч утга санаа, дүрээ бүтээдэг. Тэр тусмаа хүлэг морьдыг дүрслэхдээ өөрсдийн адууны юм уу, эсвэл нутаг орондоо алдартай хүлэг морьдоо ихэнхдээ дүрсэлсэн байна.

⁶ Хар сээрний байдал хойшоо, шонтон мөр урагшаа байж, цээжний хайрцаг тэнцэнэ.

⁷ Хонго түнхээрээ өргөн, ташаан толгой хув, хойноосоо дөрвөлжин гардаг хэмжээг бөгсний хайраг тэнцэх гэнэ.

⁸ Морь малын өвчүү орчмын газар

⁹ Сэрвээний урд, хүзүүний хойд хотгор хэсэг

Судалгааг хийхдээ олон эх сурвалж, нутаг, нутгийн хүлгийг харьцуулан судалж, нэгтгэн дүгнэж, үр дүнтэйгээр дүрийг гаргах нь цаашдын шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд хэрэг болуужин хэмээн бодном.

Сударт буй хүлгийн шинж: Хүлгийн шинжийн тухай монгол бичгээр бичсэн таван судраас хүлгийн шинжийн талаар дүрслэн бичсэн хэсгийг түүвэрлэн авав. “Мэргэн толь судар”, “Эрдэнэт хүлгийн шинжих ба уях засах судар оршив”, “Ханд вангийн хүрээний хурдан морины шинжийн нууц судруудын жинхэнэ эх оршвой”, “Шигамуни бурханд мөргөмүй, Манзуширт залбирмуй”, “Морины шинжийн нэгэн судар” зэрэг сударт хүлгийн шинжийн дүрслэн бичсэн байдаг. Үүнд: **“Мэргэн толь судар”**-т сайн моринд байх таван шинжийг *“sayin morin-u nidü inü sirügün qaraca-tai bolun uuliqarqai bögüd sirmüsün inü serteger, çegeji inü nimgen, qabčiru, mangnai anu jujarun, berbekei inü boruni, qoyidu tururai anu, morulčar urtu, sirmüsün inü keyi-tei telügü, örgün, serbege öndür, aman küjügü бүдүгүн, toluxai miq-a qatanggir, olan axuljaburi aruu, subegen-ü qabir-a matarasutai telegü, tasiy-a anu čuqal, qas anu dügüreng, saltax-a, aruu, jo niruru anu bögterge-tei, köl inü erse sidurx-a, küjügü inü narin urtu, segül inü ercitei qaturu, bögsü inü qatanggir edeger singji č-öm бүридбел түмен mingrad toruqu түдекү-үгеи тагчарар түрүгүлкү erkim sayin mori bui”* (Лувсанбалдан XIX-XX зуун) гэж өгүүлсэн байна. Судрын энэ хэсгийг харахад, хүлгийн бие эрхтэн хаа, хамаагүй дурдсан байгаа тул хүлгийн биеийг толгойн хэсэг, цээж хавирга, нуруу хондлой, 4 хөл, дэл, сүүл гэж тус тус хуваан ангилан бичлээ. Сайн морины нүд нь ширүүн харцтай болон уулихархай хэмээх нь нүдний угаараа улаан хүрэн харагддаг болохыг хэлж буй хэрэг. Толгой мах хатангир¹⁰, магнай зузаан, аман хүзүү бүдүүн (өргөн), хүзүү урт нь уралдахад дайчин байдаг. Цээж нимгэн, хавчуу, сэрвээ өндөр, сүвээний хавирга матаастай тэлүү байх нь хүлгийн нэгэн эрхэм шинжийн нэг билээ. Учир нь хавирганы хэсэг урдуураа хавчиг, хойд талаараа дугуйдуу байдаг тул хавирга урт, өргөн байгаа нь өл, хоол даах чадвар сайтайн шинж. Зоо нуруу бөгтрөгтэй байхын учир хүлэг 4 хөлөө хумин давхихад сайн эвхэрдэг юм. Олон ясны уулзвар агуу, ташаа цухал, хондлой (бөгс) хатангир хэмээх нь зоо нуруу, ташааны яс, ахар сүүлийн уулзах хэсгийг хэлдэг. Энэ хэсэг сайн байх нь хол газар явахад цуцахааргүй байдаг. Хас дүүрэн, салтаа агуу шинж нь ташаа буюу аарцаг яс өргөн давхихад түлхэх хүч сайн гэсэн үг. Хөл эрс шударга, шөрмөс нь сэртгэр хэмээх нь 4 хөл жигд хүчтэй, шөрмөс, булчингийн хоорондын зай их гэсэн үг. Бэрэвхий нь богино, хойд туурай нь, моголцог¹¹ урт, шөрмөс нь хийтэй тэлүү, сүүл нь эрчтэй хатуу, эдгээр шинж цөм бүрдвэл түмэн мянгад торох түдэхгүй ганцаар түрүүлэх эрхэм сайн морь буй хэмээжээ.

“Эрдэнэт хүлгийн шинжих ба уях засах судар”-т эрдэнэт хүлгийн нэгэн ангид шинжид

xadaradu üjel kemebel qamar anu бүрийен-ү амасар метү, mangnai degegsi qobil-tai tenigün sayin, čiki inü emünigür qotuxar, üjügür inü serteng bol olan ijil-tei gedeg. Bey-e-yin naiman singji inü: küjügü inü böke kümün-ü küjügü metü, ebčigüü inü

¹⁰ мах багатай, хатамхай

¹¹ хүвэр мод мэт хэлбэртэй юм

qarčax-a-yin ebčigü metü. Serbege inü qayinar-un uker-ün serbege metü, subege inü borusu gegüü- yin sübege metü, jo anu jirasu metü, gedesü inü bumba metü, tasiy-a anu bögesü inü bökeyijü niskü bürgüd metü, köl inü bayising-un baran-a metü sidurru silbi-ber бүдүгүн бол улам qola-du sayin, itegel-tei. Berbekei nige barim anu sayin, urtu anu маху, тухурай anu kömüresgsen тохур-a metü sayin, нимген inü маху, basa-ču qayichin-u ir metü qurča anu mōn sayin, jujaran anu sayin. Segül-ün qılrasun anu uran em-e-yin tomugsan sirbüsün metü erci-tei böged бүдүгүн inü sayin. Mangnai kömüsge qoyar anu yeke bol qola-ača ülü ayuqu sayin, küjügü urtu bol qayarula jergecen buliyalduqu-du sayin, nidü anu qar-a, qonin-u nidü metü bol öljei-tei. orutan-u nidü metü бүлтегер бол дар-a, sidüleng-degen sayin, çegeji boruni bol ögede rajar-tu sayin. çegeji inü urtu anu uruxu sayin, tegsi inü qoyarulang-du anu sayin (Лувсанбалдан XIX-XX зуун) гэж дурджээ.

Гадаад галбирыг харахад хамар бүрээний амсар мэт, магнай дээшээ ховилтой тэнүүн сайн, чих нь өмнүүр хотгор, үзүүр нь сэртэн бол сайн гэдэг. Биеийн 8 шинжийн тухай дурдсан ч 15 гаруй гадаад шинжийг дурдаж. Хүлгийн магнай, хөмсөг 2 нь их бол хол уралдахад айхааргүй. Нүд нь хар, хонины нүд мэт бол өлзийтэй. Оготнын нүд мэт бүлтгэр бол даага, шүдлэндээ сайн хэмээжээ. Хүлгийн хүзүү бөх хүний хүзүү мэт өргөн, урт бол хоёул зэрэгцэн булаалдахад сайн. Цээж богино бол өөд газарт сайн, цээж урт нь уруу сайн, тэгш нь хоёуланд нь сайн уралддаг гэжээ. Сэрвээ нь хайнагийн үхрийн сэрвээ мэт, өвчүү нь харцагын өвчүү мэт. Сүвээ нь боос гүүний сүвээ мэт, зоо нь загастай адил зоотой юм. Ташаа, бөгс нь бөхийж нисэх бүргэд мэт гэдэг бол хондлой өндөр гэсэн үг юм. Гэдэс нь бумба мэт, хөл нь байшингийн багана мэт шударга шилбээр бүдүүн бол улам холд сайн, бэрэвхий нэг барим нь сайн. Урт нь муу. Туурай нь хөмөрсөн тогоо мэт сайн, нимгэн нь муу. Бас ч хайчны ир мэт хурц нь мөн сайн. Зузаан нь сайн. Сүүлний хялгас нь уран эмийн томсон шөрмөс мэт эрчтэй бөгөөд хялгасны ширхэг гурван талтай бөгөөд бүдүүн нь сайн хэмээн дүрслэн бичжээ.

“Ханд вангийн хүрээний хурдан морины шинжийн нууц судруудын жинхэнэ эх оршвой” сударт энэ цагийн морины сайн, муу хоёрыг ялган таних талаар номложээ.

Tas-un södü metü ciki-tei, menekei metü nidü-tei, бүрий-e metü qamar-tai, arxali-yin küjügü-tei, qun-u çegeji-tei, jegere-yin üsü-tei, qabirx-a anu matarasutai bolbasu olum, kele qoyar-tu itegel-tei bui. Berbekei inü nige barim bögesü sayin, urtu anu маху, тухурай anu kömüregsen тохур-a metü sayin, нимген inü маху basa qayiči metü qurča tuxurai qurdu-tai, segül inü sayin er-e saradar arsasarsan metü, qılrasun anu uran em-e-yin tomursan sirbüsün metü. Borbi anu mergen qabu-tai kümün-ü erekei-yin ongi metü. qılrasun anu xurban tal-a-tai boluxad yerü бүдүгүн inü deger-e bui. Yasun segül бүдүгүн inü quyag-tu sayin. Tegün-eče bisi-yi sayin, маху anu magad-ügei. qongsiyari urtu-yin kereg inü sedkil arudam tula olan, qola qoyar-tu sayin. çegeji öndür inü uruxu-du sayin, çegeji boruni anu rajar ögede sayin. tubsin bögesü arulan-du sayin, angnaqu görügelekü-dü sayin. dörben köl-ün silbi бүдүгүн bögesü čuçagadıi sayin egün-I külüg-ün radar gedeg. ene čax-un metü-dü bičiqan bey-e-tei mori uçararsan tula ene yeke belge-eče ken inü čü uçarabasu jigür metü nemer bolqu. yeke, bar-a bey-e-tei sayin, маху geji olan bolqu ali singji sayitur tengčegsen

radar tere inü itegeltei gejü sayin singjiyeči-yin jakiyasu bile. radar-un belge баруу ene bile (Цэрмаа XIX-XX) гэж босоо сударт бичсэн байна.

Тасын сөд мэт чихтэй, мэлхий мэт нүдтэй, бүрээ мэт хамартай, хоншоор уртын хэрэг нь сэтгэл уудам тул олон хоног хол явахад сайн хэмээх нь. Аргалын хүзүүтэй, хунгийн цээжтэй, зээрийн үстэй, хавирга нь матаастай болбоос олом, хэл хоёрт итгэлтэй буй. Цээж өндөр нь урууд сайн, цээж богино нь газар өөд сайн, түвшин бөгөөс ууланд сайн. Агнах гөрөөлөхөд сайн хэмээж буй. Бэрэвхий нь нэг барим бөгөөс сайн, урт муу, туурай нь хөмөрсөн тогоо мэт сайн, нимгэн нь муу бас хайч мэт хурц туурай хурдтай, сүүл нь сайн эр саадаг агссан мэт, хялгас нь уран эмийн томсон шөрмөс мэт. Борви нь мэргэн хавтай хүмүүний эрхийн онч мэт. Хялгас нь гурван талтай болоод ер бүдүүн нь дээр буй. Ясан сүүл бүдүүн нь хуягт сайн, түүнээс бишийг сайн, муу нь магадгүй. Дөрвөн хөлийн шилбэ бүдүүн бөгөөс цуцаагүй сайн үүнийг хүлгийн гадар гэдэг. Энэ цагт бяцхан биетэй морь учирсан тул энэ их бэлгээс хэн нь ч учирваас жигүүр мэт нэмэр болох. Их, бага биетэй сайн, муу гэж олон болох аль шинж сайтар тэнцсэн гадар тэр нь итгэлтэй гэж сайн шинжээчийн захиас билээ. Гадрын бэлгэ бараг энэ билээ.


“Шигамуни бурханд мөргөмүй, Манзуширт залбирмуй” сударт дурдсан эрхэм сайн морины шинж нь *“sirigün qarača-tai böged sirbüsün ni serteger, çegeji ni nimgen, qabčiru, mangnai ni jujaran, berbekei ni boruni, qoyidu tururai-yin morulčar urtu, sirbüsün ni kei-tei telegü, örgen, serbege öndür, aman küjügü бүдүгүн, toluxai-yin miq-a qatanggir, olan yasun-u aruljaburi aruu, sübegen-ü qabirx-a matarasu-tai telegü, tasiy-a ni čuqal qas ni dügüreng, saltar-a ni aruu, jo-a niruxu ni bögtege-tei, köl ni eres sidurgu, küjügü ni urtu narin segül ni erčim-tei qataru, böge ni qatanggir edeger singji čöm бүридбел түмен mingrad törükü түдекү-үгеи xaxčaxar түрүгүлкү amui”* (Алтантуяа XIX-XX зуун) бичсэн байна.

Нүд нь ширүүн харцтай бөгөөд шөрмөс нь сэртгэр, цээж нь нимгэн, хавчуу, магнай нь зузаан, бэрэвхий нь богино, хойд туурайн моголцог урт, шөрмөс нь хийтэй тэлүү, өргөн. Сэрвээ өндөр, аман хүзүү бүдүүн, толгойн мах хатангир, олон ясны уулзвар агуу, сүвээний хавирга матаастай тэлүү, ташаа нь цухал хас нь дүүрэн, салтаа нь агуу, зоо нуруу нь бөгтрөгтэй, хөл нь эрс шударга, хүзүү нь урт нарийн сүүл нь эрчимтэй хатуу, бөгс нь хатангир эдгээр шинж цөм бүрдвэл түмэн мянгад төрөх түдэхгүй ганцаар түрүүлэх хүлэг энэ болой. Судар хүлгийн шинжийг дүрслэн бичсэн нь энэхүү судар болон Мэргэн толь сударт дурдсантай бараг адил байна.

“Морины шинжийн нэгэн судар”-т Эрдэнийн хүлэг морийг шинжихэд эхлээд гадар биенийг шинжил гээд морины сайн гадрыг тоочсон байна. Үүнд:

Erkim sayin inü manglai anu temür toil, qangsiyar anu matar, uruxul, qamar anu бүрий-e, nidü inü oxutan-a, sormuus anu uker, uqarqai anu künker, čiki inü tas-un mögüü, küjügü inü xur-un küjügü, omruxu anu buq-a, serbege inü qayinux, jo anu jixasu, qajaru anu buru, qondulai anu buur-a, köke miq-a anu kömüregsen torux-a, qabirx-a anu dededü soyux-a, borbi anu mergen kümün-ü erekei, segül inü uran em-e-yin utasu, gedesü inü gegüü, bulking anu bumba, dörben köl sirege, belberkei temür xadasu, tururai anu gün jujaran, saltar-a anu čar bagtaqu, tasiy-a anu tas-un mör, eregü inü talki-yin aral, ebüdeg inü baratur kümün-ü manglai, emün-e-eče üjebel saruxsan načın metü, qoyin-a-ača üjebel qarbarsan sumu metü, ed бүгүде бүридкү keregtei (Лувсанбалдан 1989, 142-143).


Бурханч лам Г.Пүрэвбатын “Хурдан морь” (Зураг 1)-ны дүрсэнд босоо, хэвтээ тэнхлэгт зураасыг байрлуулсан. Босоо тэнхлэгийн дагуу урд хөлийн туурайн ирмэгээс сэргээний голын өндөр цэг хүртэл шар өнгийн хэрчим зурсан. Хүлгүүдийн цээжний өндрийг хэрчмээр тэмдэглэн, урд хөлийн урттай харьцуулахад цээж нь үл ялиг урт байна. Нэг ёсондоо богтос яс, борвины яс богино байна гэсэн үг. Морины гурван овооны хоорондын зайг цэнхэр өнгөөр хэрчим татаж үзэхэд, дагзнаас сэргээ хоорондын зай, сэргээнээс харгам овоо хооронд хэрчмийн зай богино байна. Морины гавал ясны уртыг хэмжсэн улаан хэрчмийг далны урт, хондлойн урт, хойд шилбэ дээр байрлуулж уртыг харьцуулан хэмжихэд, “гавал ясны урт, хондлойн урт, хойд шилбэний урт адил, харин далны яс нь арай богино” зурагдсан байна. Хүлгийн их биеийн ташуу уртыг өндөртэй харьцуулахад намхан байна.



Зураг 1. Г.Пүрэвбат “Хурдан морь” 25x36.5 см¹²


¹² Пүрэвбат 2017, 323

Хурдан морь шинжээч, зураач А.Батболдын “Аварга хурдан морины шинж”-ийн (Зураг 2) зургийн дүрслэлд босоо, хэвтээ тэнхлэгт зураасыг байрлуулсан. Босоо тэнхлэгийн дагуу урд хөлийн туурайн ирмэгээс сэрвээний голын өндөр цэг хүртэл шар өнгийн хэрчим зурсан. Хүлгүүдийн цээжний өндрийг хэрчмээр тэмдэглэн, урд хөлийн урттай харьцуулахад цээж нь хөлөөс арай богино байна. Богтос яс, борвины ясыг уртдуу зуржээ. Морины гурван овооны хоорондын зайг цэнхэр өнгөөр хэрчим татаж үзэхэд, дагзнаас сэрвээ хооронд, сэрвээнээс харгам овоо хооронд хэрчим татахад хүзүүний уртын зай нь нурууны зайнаас богинохон байна. Тэгэхээр сээр, нуруу урт гэсэн үг. Зураач мориныхоо нуруу ясыг бөгтөр ихтэй зурсан тул нуруу нь урт болжээ. Морины гавал ясны уртыг хэмжсэн улаан хэрчмийг далны урт, хондлойн урт, хойд шилбэ дээр байрлуулж уртыг харьцуулан хэмжихэд, гавал ясны урт, далны ясны урт ижил хэмжээтэй, харин хондлой, хойд шилбэний яс нь богино зурагджээ. Хүлэг морины их биеийн ташуу уртыг, өндөртэй харьцуулахад яг таг таарч байна. Учир нь уран бүтээлч маань хүлгийн шинжийг хэт баримталсан нь бодит олон монгол мориноос хэмжээ аваагүйтэй холбоотой байх гэж таамаглаж байна.




Зураг 2. Зураач А.Батболд “Аварга хурдан морины шинж” –ийн зураг

Уран барималч Г.Энхтөр “Арвагар хээр морь”-ны (Зураг 3) баримлын эх загварын дүрслэлд босоо, хэвтээ тэнхлэгт зураасыг байрлуулахад босоо тэнхлэгийн дагуу урд хөлийн туурайн ирмэгээс сэрвээний голын өндөр цэг хүртэл шар өнгийн хэрчмийн зураасанд, цээжний өндөр болон урд хөлийн урттай харьцуулахад, цээжний зайнаас урд хөлийн зай их байна. Арвагар хээр морины гурван овооны хоорондын зайг цэнхэр өнгөөр хэрчим татаж үзэхэд, дагзнаас сэрвээ хооронд, сэрвээнээс харгам овоо хооронд хэрчим татахад ялгаагүй байна. Энэ нь гурван овоо тэгш буюу морины татах, түлхэх хүч сайтай гэж бүтээсэн байна. Морины гавал ясны уртыг хэмжсэн улаан хэрчмийг далны урт, хондлойн урт, хойд шилбэ дээр байрлуулж уртыг харьцуулан хэмжлээ. Үүнд гавал яс, далны яс, хондлойн ясны уртын хэрчмийн зай ижил байна. Харин хойд шилбэ их урт байна. Энэ нь морины 4 шилбэний урт хэт урт болжээ. Арвагар хээр морины их биеийн ташуу уртыг, өндөртэй харьцуулахад бага зэрэг намхан бүтээгдсэн байна.



Зураг 3. Уран барималч Г.Энхтөр “Арвагар хээр морь” 2008 он

Уран барималч Н.Цогмагнай “Даян түмэн эх” (Зураг 4) баримлын эх загварын дүрсэнд босоо хэвтээ тэнхлэгт зураасыг байрлуулсан. Босоо тэнхлэгийн дагуу урд хөлийн туурайн ирмэгээс сэрвээний голын өндөр цэг хүртэл шар өнгийн хэрчим татаж харьцуулан үзэхэд, “Даян түмэн эх” хүлгийн цээжний өндрийг хэрчмээр тэмдэглэн, урд хөлийн урттай харьцуулахад адил байна. Морины гурван овооны хоорондын зайг цэнхэр өнгөөр хэрчим татаж үзэхэд, дагзнаас сэрвээ хооронд, сэрвээнээс харгам овоо хооронд хэрчим татахад бага зэргийн ялгаатай байна. Хүзүүний хэрчмийн зай, нурууны хэрчмийн зайнаас маш бага зэргийн урт байна. Морины гавал ясны уртыг хэмжсэн улаан хэрчмийг далны урт, хондлойн урт, хойд шилбэ дээр байрлуулж уртыг харьцуулахад, гавал яс, далны ясны уртын хэрчмийг зай ижил байна. Харин хойд шилбэ их урт, хондлойн ясны уртын хэрчмийг зай бага буюу богино байна. “Даян түмэн эх” морины их биеийн ташуу уртыг, өндөртэй харьцуулахад бага зэрэг намхан бүтээгдсэн байх жишээтэй.



Зураг 4. Уран барималч Н.Цогмагнай “Даян түмэн эх” 2022 он, 25x50x5см, Пластик

Хэлэлцүүлэг

Морьдын биеийн өндөр, уртын хэмжээг нь нийт уртын эзлэх хувиар олоход их биеийн ташуу уртыг 100% гэж үзээд, сэрвээ-мундаа овооны цэгийн өндрүүдийг (Хүснэгт 1) харьцуулан үзэхэд “Хурдан морь” (Зураг 1) 90%, “Аварга хурдан морины шинж” (Зураг 2) нь 100%, “Арвагар хээр морь”-ны баримал (Зураг 3) 97%, “Даян түмэн эх” баримал (Зураг 4) 95%-тай байгаа нь ажиглагдлаа. Харгам овооны цэгийг үзэхэд, “Хурдан морь” зураг 90%, “Аварга хурдан морины шинж”-ийн зураг 96%, “Арвагар хээр морь”-ны баримал 95%, “Даян түмэн эх” баримал 92%-тай байна.

Морьдын дүрслэлийн аман хүзүүний цэг нь хамгийн өндөр цэг юм. Үүнээс үзэхэд, “Хурдан морь” зураг 90% байх бөгөөд “Аварга хурдан морины шинж”, “Арвагар хээр морь”, “Даян түмэн эх” баримлын зураг зэрэг нь бидний авсан нийт өндрийн хэмжээнээс илүү гарч байна. Үүнд, нийт өндрийг 100% гэж үзвэл, “Даян түмэн эх” баримлын зураг дахь морины өндөр 2%-аар илүү байна.

“Аварга хурдан морины шинж”-ийн зураг, “Арвагар хээр морь”-ны баримлын зураг дахь морины өндөр 3%-аар илүү байна. Энэ нь хүлгийн шинжийн хэмжээнээс морины толгой дээр байрлалтай дүрслэгдсэн гэсэн үг. Аман хүзүүний цэг, сэрвээ овооны өндөр цэг, харгам овооны цэгийн өндөртэй харьцуулахад, “Хурдан морь” зураг 90%-90%-90%, “Аварга хурдан морины шинж”-ийн зураг 103%-100%-96%, “Арвагар хээр морь”-ны баримал 101%-97%-95%, “Даян түмэн эх” баримал 103%-95%-92%-тай байна. Үүнээс харахад, “Хурдан морь” зургийг нэг түвшинд зурсан нь монгол хүлгийн шинжийн бэлгэдлийг бодолцон бүтээсэн бололтой. “Аварга хурдан морины шинж”-ийн зургийн морины сэрвээний 100% өндөртэй бусад 3 зургийг харьцуулахад, “Арвагар хээр морь”-ны сэрвээ 2%, “Даян түмэн эх” морины сэрвээ 5%, “Хурдан морь” зургийн морины сэрвээ 10% байгаагаар уран бүтээлчид маань намхан уртавтар дүрсэлсэн нь харагдаж байна. Харгам овооны цэгийг зоо нурууны цэгтэй харьцуулан үзэхэд, “Хурдан морь” зургийг морины зоо нурууны өндрөөс харгам овооны цэг нь 1% өндөр байгаа нь зоогоороо бөгтрөггүй зурагдсан. “Аварга хурдан морины шинж”-ийн зургийн морины зоо нурууны өндрөөс харгам овооны цэг нь 2% нам байгаа нь зоогоороо бөгтрөг ихтэй байна гэсэн үг. “Арвагар хээр морь” морины зоо нурууны өндрөөс харгам овооны цэг нь 1% нам байгаа нь зоогоороо бага зэрэг бөгтрөгтэй байна. “Даян түмэн эх” морины зоо нурууны өндрөөс харгам овооны цэг нь 1% өндөр байгаа нь зоогоороо бөгтрөггүй, шулуун нуруу утайгаар бүтээжээ.

Энэхүү дөрвөн уран бүтээлчийн зургуудыг харахад, морьдын толгойн налуу адил, 4 мөч их биеэс урт, чихний уг бүдүүн, үзүүр хурц, нүд дүүрэн, хамрын самсаа том, сэрвээ уул мэт овгор, хавирганы матаас сайтай, онжирого зай сайтай, түүшүү шанаа, хонгоны булчин сайтайгаар бүтээсэн байна. Морьдын бас нэг нийтлэг шинж нь 4 хөлийн уг бүдүүн сайтай, 4 шилбэ бүдүүн бүтээсэн байна.

Хүснэгт 1. Морьдын өндрийн хэмжээ

Нэрс	Г.Пүрэвбат “Хурдан морь”		А.Батболд “Аварга хурдан морины шинж”		Г.Энхтөр “Арвагар хээр морь”		Н.Цогмагнай “Даян түмэн эх”	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хамрын үзүүр	54	61	69.5	78	63	71	62.0	70
Хоншоорын цэг	63	71	81.5	92	74	83	73.0	82
Аман хүзүүний цэг	80	90	92	103	90	101	92.0	103
Хүзүүний гүдгэрийн цэг	79	89	89.5	101	87.5	98	90.0	101
Омрууны цэг	79	89	87	98	84	94	83.0	93
Сэрвээ-Мундаа овооны цэг	80	90	89	100	86	97	84.5	95
Мундааны хойд цэг	77.5	87	84.5	95	83.5	94	80.5	90
Нурууны хотгорын цэг	77	87	84	94	83	93	80.0	90
Зоо нурууны цэг	79	89	87	98	85	96	81.0	91
Харгам овооны цэг	80	90	85	96	84.5	95	81.5	92
Сүүлний угийн цэг	71.5	80	70	79	73.5	83	69.0	78
Хонгоны гадна талын цэг	59.5	67	65	73	65	73	63.0	71
Суга аюулхайн мөгөөрсний цэг	38	43	48	54	47	53	42.0	47
Онжрогоны цэг	51	57	57	64	56	63	53.0	60

Сурвалжид “Хар сээрний яс нь шургаад орчихсон, шонтон мөр нь хойшоо байрлалтай, дал босоо байдаг. Хүн харахад эвхэж тавиад давхиад байгаа хэр нь газар хороодгүй” гэж бичсэн байдаг нь хурдлах чадваргүй ч унаанд сайн морийг хэлдэг. Мөн нэгэн сонин хэмжээс нь хонгоны гадна талын цэгээс сүүлний угийн цэг хоорондын зай болоод хүлгийн хонгоны зай, сүүлний угийн зай их, хондлойн гадна булчингийн хөгжил их байгаа нь хүч сайтай, хол харайдаг гэсэн утгатай.

Нийт уртын эзлэх хувиар их биеийн уртын хэмжээг харьцуулахад, морьдын биеийн ташуу уртыг 100% гэж үзээд, сэрвээний өндөр цэгээс урагш омрууны цэг, хойш мундааны хойд цэгийн хоорондын зайг хувиар харьцуулан (Хүснэгт 2) тоон судалгааны аргачлалаар тэмдэглэлээ.

Сэрвээний өндөр цэгээс урагш омрууны цэг хоорондын зайнаас хамаарч хурдан морины хүч, тамирыг нь шинждэг. “Хурдан морь” зургийн сэрвээний өндөр цэгээс урагш омрууны цэг хооронд 21% зайтай, “Аварга хурдан морины шинж”-ийн зураг 9%, “Арвагар хээр морь”-ны баримал 20%, “Даян түмэн эх” баримал 16%-тай байна. Эндээс үзэхэд, сэрвээний өндөр цэгээс урагш омрууны цэг хоорондын зай тодорхой хувь хэмжээс холдох тусам хурдны шинжтэй буй за. Мөн, бас нэг чухал шинжийн хэмжээс болох сэрвээний өндөр цэгээс хойш сэрвээний хойд цэгийн хоорондын зайг харьцуулахад, “Хурдан морь” зураг 11%, “Аварга хурдан морины шинж”-ийн зураг 15%, “Арвагар хээр морь”-ны баримал 12%,

“Даян түмэн эх” баримал 16%-тай байна. Сэрвээний өндөр цэгээс хойш сэрвээний хойд цэг хоорондын зай тодорхой хувь хэмжээс холдох тусам хурдны түлхэх хүч сайтайгаар бүтээжээ.

Хүснэгт 2. Морьдын уртын хэмжээ, биеийн ташуу

Нэрс	Г.Пүрэвбат “Хурдан морь”		А.Батболд “Аварга хурдан морины шинж”		Г.Энхтөр “Арвагар хээр морь”		Н.Цогмагнай “Даян түмэн эх”	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хамрын үзүүр	138	155	142	160	138.5	156	135	152
Хоншоорын цэг	136.5	153	134.5	151	136	153	134	151
Аман хүзүүний цэг	116.5	131	113.5	128	113	127	113	127
Хүзүүний гүдгэрийн цэг	111	125	103	116	104	117	104	117
Омрууны цэг	89	100	77	87	87	98	83	93
Онжрогоны цэг	89	100	89	100	89	100	89	100
Сэрвээ-Мундаа овооны цэг	70.5	79	69	78	69	78	69	78
Суга аюулхайн мөгөөрсний цэг	68	76	69	78	69	78	70	79
Мундааны хойд цэг	61	69	55.5	62	58	65	55	62
Нурууны хотгорын цэг	59	66	51	57	64	72	52	58
Зоо нурууны цэг	36.5	41	30	34	30	34	30	34
Харгам овооны цэг	30	34	19	21	23	26	21	24
Сүүлний угийн цэг	6	7	1	1	3	3	1.5	2
Хонгоны гадна талын цэг	0	0	0	0	0	0	0	0

Эдүгээ цагт монгол хүлэг, морьдын дүрслэлээр дагнан уран бүтээл хийдэг зураач А.Батболд, барималч Г.Энхтөр, Н.Цогмагнай нарын уран бүтээлүүдийг сонгон авч дүн шинжилгээ хийсэн. Мөн Бурханч лам хэмээн алдаршсан Г.Пүрэвбатын олон жилийн судалгаагаар бүтээсэн монголын уламжлалт урлах ухааныг баяжуулан хөгжүүлсэн бурхдыг бүтээх хувь хэмжээний шугамын онолын нэгэн төрөл зүйл болох амьтны зохист харьцааны онол байдаг. Үүний нэг нь малын галбир зүйн онолын үндэс юм. Тэдгээрийн дотор хүлэг морины дүрслэлийг бусад бүтээлүүдтэй харьцуулан судалсан болно. Дөрвөн уран бүтээлчийн хүлгийн дүрслэлийг “Хэмжээст их хайрцаглах аргачлал”-ын форматад оруулж, байрлуулан ялгаатай болон адил төстэй талуудыг холимог аргачлалаар шинжилгээ хийсэн талаар дурдлаа. Энэхүү хүлгүүдийн хэмжээ тодорхойлсноор, цаашдын судалгаандаа ашиглан хүлгийн дундах хэмжээсийг тодорхойлох боломжтой хэмээн үзэж байна.

Дүгнэлт

Монголчуудын эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлсийн нэг болох нүүдэлчний ухааныг бүрдүүлэгч гол бүрэлдэхүүн хэсэг нь адууны соёл билээ. Энэхүү соёлтой холбоотой ойлголтыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр олон нийтэд таниулсан энэхүү бүтээл нь цаашид олон төрлийн судалгааны эх сурвалж болон өргөнөөр ашиглагдах ач холбогдолтой ажил болно гэж бодно. Өнөө цагт монгол хүлгийн дүр төрхөөр дагнан уран бүтээл туурвидаг дөрвөн уран бүтээлчийн бүтээлээс тус бүр нэгийг сонгон авч, хүлгүүдийн гадаад дүр төрхөд дүн шинжилгээ хийсэн юм.

Хүлгийн шинжийг эртний сударт тэмдэглэсэнтэй бидний сонгосон дөрвөн хүлгийн дүрслэл нь *“Толгой мах хатангир, ам хамар дорвоггор хуниастай, дээд уруулаас доод уруул илүү, арслан мэт эрүүтэй, хониоор урт”, “Цээж нимгэн, өвчүү өргөн, далаар ташуу урт, арьс нь сул, булчин нь товгор, гурван овоо тэгш”¹³, ташаа өргөн, салтаа уужим”, “Хөл бадируун, шилбэ бүдүүн, гадагшаа тэлгэр, туурай нь хөмөрсөн тогоо мэт, хурц, зузаан байх нь эрхэм сайн шинж нь түмэн мянгад төрж, ганцаар түрүүлэх эрхэм сайн морь”* хэмээсэнтэй яг цав таарч байна.

Тэгвэл “Хэмжээст их хайрцаглах аргачлал”-ын форматад оруулан дүн шинжилгээ хийхэд, хүлгийн биеийн өндөр, уртын хэмжээг нь нийт уртын эзлэх хувиар олоход “Аварга хурдан морины шинж”, “Арвагар хээр морь” бүтээлийн дүрслэлүүдийн дүрийн зан чанарыг илэрхийлэх цэгүүд 95 хувь таарч байна. Харин “Арвагар хээр морь” дүрслэлийн дүрийн зан чанарыг илэрхийлэх цэгүүд нь өмнөх 2 бүтээлийн хүлгийн дүрслэлтэй 90 орчим хувьтай ойролцоо байгаа бол бурхны тигийн онолоор зурсан “Хурдан морь” нь дүрийн зан чанарыг илэрхийлэх цэгүүд нь 50 ч хувь хүрэхгүй байна. Бурханы тигийн онолоор зурсан “Хурдан морь” бүтээл нь бодит хүлгийн дүрслэлтэй таарахгүй байгаа ч сударт бичсэн хүлгийн шинжтэй бол яв цав таарч байгаа юм. Үүнээс үзэхэд, “Хурдан морь”, “Аварга хурдан морины шинж”, “Арвагар хээр морь”, “Даян түмэн эх” хүлгүүдийн бүтээлүүд нь сударт буй хүлгийн шинжийн бэлгэдэлт дүрслэлтэй бүгд таарч байгаа юм. Тэгэхээр сударт буй хүлгийн шинжийн талаар дүрслэн бичсэнтэй харьцуулахад, манай уран бүтээлчид маань хурдан хүлэг морио сайн мэддэг төдийгүй хүлгийн шинжийг судлан бүтээл туурвилдаа ашигладаг нь тодорхой байна.

Ийнхүү уламжлалт эх сурвалжид тэмдэглэгдсэн хүлгийн шинжүүдийг орчин цагийн уран бүтээлчдийн зурсан морьдтой харьцуулан үзэхэд, дүрслэлүүд нь ерөнхийдөө нийцж байгааг судалгааны үр дүн харуулж байна. Энэ нь манай уран бүтээлчид хурдан хүлгийн уламжлалт шинж, хэв маягийг гүн гүнзгий судлан, бүтээл туурвилдаа амжилттай тусган харуулдаг болохыг баталж байна.

¹³ дух, мундаа, олон яс уулзах, харгам овоог хэлнэ

Ашигласан материалын жагсаалт

- Алтантуяа, Б. (хөрв). “Заяын хүрээний хурдан морины судар.” *Шигамуни бурханд мөргөмүй, Манзуширт залбирмуй*. Архангай аймаг.
- Гансүх, Энхтайван. 2025. “Монгол хүлгийн шинжийг судлан дүрслэх нь.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Лувсанбалдан, Х. (хөрв). *Эрдэнэт хүлгийн шинжих ба уях, засах судар оршив*.
- Лувсанбалдан, Х. 1989. *Хүлгийн шинж*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.
- Намнандорж, О. 1989. *Монголын хурдан морины тухай*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Цэрмаа, Д. (хөрв). “Хурдан морины нууц судар.” *Ханд вангийн хүрээний хурдан морины шинжийн нууц судруудын жинхэнэ эх оривой*. Булган.
- Чоймаа, Ш. 2017. “Монгол хэл, бичиг, соёл судлал.” *Эрдэм шинжилгээний чуулган II*. Улаанбаатар.